



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 28 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “дотоодын цэрэг,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх,” гэж, 9.3 дахь хэсгийн “дотоодын цэргийн командлагч,” гэсний дараа “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “хил хамгаалалтын” гэснийг “хил хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР